



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/400

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээт дуудлага
Худалдаа зохион байгуулах комисс
томилох тухай

Монгол улсын “Газрын тухай” хуулийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээт цахим дуудлага худалдааг аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн А/363 дугаар захирамжийн дагуу зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Комиссын дарга: Б.Намуун–Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: О.Мөнхцэцэг–Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Гишүүд: Ж.Лхамдулам–Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

2. Дуудлага худалдааг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Газрын цахим бирж MLE.mn сайтаар дуудлага худалдаа цахимаар зохион байгуулж, үр дүнг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 14 хоногт багтаан Засаг даргын зөвлөлд танилцуулахыг дуудлага худалдааны комисст үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621011009